10.1.1. Дипломын дугаар захиалга үүсгэх

Захиалга үүсгэх үйлдэл хийхээс өмнө **ДАРААХ НӨХЦӨЛ** биелсэн байх шаардлагатай. **Үүнд**:

- Захиалгын нэр давхцахгүй байх
- Идэвхтэй төлөвт байгаа суралцагчаас төгсөх суралцагч сонгох
- Төгсөхөөр сонгогдох суралцагч өмнө нь ижил хөтөлбөрөөр дипломын захиалга хүлээгдэж байгаа, зөвшөөрсөн, дипломын дугаар бүртгэсэн, олгосон байж болохгүй.

Захиалга үүсгэх үйлдлийг дараах дарааллаар хийнэ. **Үүнд**:

1. **Төгсөлт** ерөнхий цэсийг сонгоно.
2. Төгсөлт дэд хэсгээс **дугаар захиалг**ыг сонгоно.
3. Цонхны баруун дээд хэсэгт байрлах **захиалга үүсгэх** товчийг дарна.
4. Дугаар захиалга үүсгэх цонхны мэдээллийг оруулаад **хадгалах** товч дарна.

Захиалга үүсгэх үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Төгсөлт** ерөнхий цэсийг сонгоно



2. Төгсөлт дэд хэсгээс **дугаар захиалг**ыг сонгоно.



3. Цонхны баруун дээд хэсэгт байрлах **захиалга үүсгэх** товчийг дарна.



4. Дугаар захиалга үүсгэх цонхны мэдээллийг оруулаад **хадгалах** товч дарна.



Захиалга үүсгэх мэдээллийн тайлбар

№	Талбар	Тайлбар	Жишээ
1	Сургалтын байгууллага	Сургалтын байгууллагын нэр	МУБИС
2	Сургууль	Салбар, бүрэлдэхүүн сургуулийн нэр	Боловсрол судлал сургууль
3	Захиалгын нэр	Дипломын дугаарын захиалгын нэр бичнэ. Нэр нь давхцахгүй байна.	2019 оны өвөл
4	Захиалга илгээсэн огноо	Захиалга илгээсэн огноо	2019.02.01
5	Боловсролын зэрэг	Боловсролын зэрэг сонгоно.	Бакалаврын зэрэг
6	Хичээлийн жил	Захиалга хийж буй хичээлийн жил сонгоно.	2018-2019
7	Хичээлийн улирал	Захиалга хийж буй улирал сонгоно.	1-р семестр
8	Захиалгын тоо	Дипломын дугаар захиалж буй суралцагчийн тоо	45
9	Зөвшөөрсөн суралцагч	Захиалгыг зөвшөөрч дугаар хуваарилах суралцагчийн тоо	30
10	Татгалзсан суралцагч	Захиалга цуцлагдсан суралцагчийн тоо	15
11	Хуваарилсан дугаар	Захиалга шийдвэрлэн хуваарилсан дугаарын тоо	20
12	Захиалгын төлөв	Захиалгын төлөв харуулна.	Хүлээгдэж байгаа